



# КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2023 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

# БИДНИЙ ТУХАЙ

Компани нь 2002 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд ус суваг, засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулах баримт бичигт заасан. Компани нь 2020 онд үйл ажиллагаа явуулаагүй. 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр нэр бүхий хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр Ард Бит ХХК нь компанийн 99.9 хувийн хувьцааг худалдаж авсан. Ингэснээр цаашид компанийн үйл ажиллагааг сэргээж, блокчэйн технологи болон криптовалютын салбарт үйл ажиллагаа явуулахаар болсон.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон ээлжит бус хурлаараа компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлэл хүргэх зэргээр компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх бэлтгэл ажлыг шат дараатайгаар хийж гүйцэтгэж байна.

# КОМПАНИЙН ТУХАЙ



Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код

---

**Крипто Үндэстэн ХК, 410001002, MSE:CNF**



Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг

---

**113,212**



Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр

---

**Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК**



Бизнесийн үйл ажиллагааны салбар

---

**Гадаад худалдаа  
Криптовалют судалгаа  
Бизнесийн зөвлөгөө  
Технологи, хөрөнгө оруулалтын зөв**

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ

2023 онд компанийн стратегийн чиглэлд өөрчлөлт оруулж, цаашид үйл ажиллагаагаа төрөлжүүлэх, өргөжүүлэх хэд хэдэн чухал шийдвэрийг гаргаж виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч idax, АрдКойн лоялти оноог гаргагч Ард Бит, стэйблкойн болох Монгол Тетерыг гаргагч Монгол ДиФай, блокчэйн хөгжүүлэгч Дайверс Солюшнс, мета платформ Металандыг хөгжүүлэгч Метафорс, NFT зах зээл болох Ард Арт, крипто мэдээллийн цогц сайт Krypto.mn, лоттоны МПерс зэрэг компаниудын хувийг Крипто Үндэстэн ХК-д нэгтгэсэн.

2023 оны 3 сарын 30-ны өдөр Хү хамтлаг - Ард Санхүүгийн Нэгдлийн дэмжлэгтэйгээр The NU in the Metaverse тоглолтоо хийсэн бөгөөд уг Виртуал орчинд хийгдэх уг тоглолтод Ард болон ТэнГэрЛиг Медиа Нэгдэл, МОСТ Финтек, ГрэйпСити, Дайвэрс Солюшнс, idax, МетаФорс, Ард Бит, Ард Арт, Монгол ДиФай зэрэг технологи, санхүүгийн компаниуд хамтран ажиллаж, дэлхийд анх удаа зохиогдох мета рок концертыг амжилттай зохион байгуулсан. Энэхүү тоглолтоор монголын түүх соёл, амин сүнс, бодит ертөнцөд харуулж чадахгүй байгаа зүйлийг хязгааргүй орчинд, технологийн түслэмжтэй Мета орчинд харуулж чадсан ба дахин давтагдахгүй хэлбэрээр тухайн тоглолтын тасалбар, хамтлагийн гишүүний аватар нэмээд тусгай хөдөлгөөнүүдийг NFT хэлбэрээр авах боломж олгосон.

2023 оны 08 сарын 19 - Nas Daily-ийн хамт олон Nas Summit Mongolia арга хэмжээг Ард Санхүүгийн Нэгдэл болон Крипто Үндэстэн ХК-ийн оролцоотой зохион байгуулж, нийт 1700 гаруй залуус, 30 гаруй илтгэгч, 20 гаруй медиаг цуглуулж чадсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд Nas Summit-ийн гол спонсор болох Solana Foundation-той хамтран ажиллах санамж бичгийг байгуулж цаашдын хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан.

2023 оны 10 сарын 30-наас 11 сарын 3-ны өдрүүдэд Нидерланд Улсын Амстердам хотод зохион байгуулагдаж буй Solana Breakpoint 2023 Форумд Ард Санхүүгийн Нэгдлийн Зөвлөлийн Дарга Ч.Ганхуяг уригдаж, Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох зорилгынхоо хүрээнд 10 жилийн турш хийсэн ажлаа крипто ертөнцийн томоохон арга хэмжээнд танилцуулж, АрдКойн урамшууллын онооны өвөрмөц шийдэл, экосистем, токеномикс болон цаашдын төлөвлөгөөг олон улсын крипто идэвхтэн, мэргэжилтнүүдэд анх удаагаа сонордуулсан.

2023 оны 12 сарын 15-ны өдөр Ардкойн 3.0 амжилттай нэвтэрлээ. Hacken олон улсын блокчэйн болон технологийн аудит давсан, ERC20, BEP20 болон Matic 3 блокчэйн дамнасан, 400 мянган эзэмшигчтэй Ардкойны гүйлгээний шимтгэл 135 дахин буурлаа.

Үүнээс гадна виртуал хөрөнгийн одоогийн багцад Bitcoin (BTC), Ethereum (ETH), Ardcoin (ARDX), staked ETH (sETH), ARDM болон USDC багтаж байгаа болно

## # САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	2022 -12-31	2023-12-31
<strong>Хөрөнгө</strong>		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	469,795	995,189
Дансны авлага	759,188,169	760,617,975
Бусад авлага	10,498,686	38,148,870
Бусад санхүүгийн хөрөнгө		216,473,390
Урьдчилж төлсөн зардал	5,386,679	278,205,604
Бусад эргэлтийн хөрөнгө	4,172,953,572	4,485,059,267
Эргэлтийн бус хөрөнгө		1,495,848
Хойшлогдсон татварын хөрөнгө	29,487,968	
<strong>Нийт хөрөнгө</strong>	<strong>4,977,984,869</strong>	<strong>5,780,996,143</strong>
<strong>Өр төлбөр ба эздийн өмч</strong>		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны болон бусад өглөг	381,813,695	609,035,804
Татварын өглөг	671,322	3,447,600
Урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон татварын өр төлбөр		157,678,262
<strong>Өр төлбөрийн нийт дүн</strong>	<strong>382,485,017</strong>	<strong>770,161,666</strong>
<strong>Эздийн өмч</strong>		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	11,321,200	11,321,200
Нэмж төлөгдсөн капитал	8,421,200	8,421,200
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		1,419,104,355
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	4,380,000,000	3,464,259,336
Хуримтлагдсан ашиг алдагдал	195,757,452	107,728,387
<strong>Эздийн өмчийн дүн</strong>	<strong>4,595,499,852</strong>	<strong>5,010,834,477</strong>
<strong>Нийт өр төлбөр ба эздийн өмч</strong>	<strong>4,977,984,869</strong>	<strong>5,780,996,143</strong>

## #ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	2023-12-31
Хүүний орлого	28,004,508
Бусад орлого	19,782,985
Борлуулалт, маркетингийн зардал	
Ерөнхий ба удирдлагын зардал	143,486,120
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	7,463,583
Бусад ашиг (алдагдал)	
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-88,235,044</b>
Орлогын татварын зардал	
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-88,235,044</b>
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-88,235,044
Бусад дэлгэрэнгүй орлого	
<b>Орлогын нийт дүн</b>	<b>-88,235,044</b>
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	

# #ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(мянган төгрөг)

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31</b>	<b>11,321</b>	<b>8,421</b>	<b>0</b>	<b>4,380,000</b>	<b>248.660</b>	<b>4,648,403</b>
Залруулсан үлдэгдэл	11,321	8,421	0	4,380,000	248.660	4,648,403
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	-	(52,903)	(52,903)
<b>2022 оны 12-р сарын 31</b>	<b>11,321</b>	<b>8,421</b>	<b>0</b>	<b>4,380,000</b>	<b>195,757</b>	<b>4,595,499</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	206	206
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>11,321</b>	<b>8,421</b>	<b>0</b>	<b>4,380,000</b>	<b>195,963</b>	<b>4,595,706</b>
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	-	(88,235)	(88,235)
Бусад дэлгэрэнгүй орлого			1,419,104	(915,741)		503,364
<b>2023 оны 12-р сарын 31</b>	<b>11,321</b>	<b>8,421</b>	<b>1,419,104</b>	<b>3,464,259</b>	<b>107,728</b>	<b>5,010,834</b>



## Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт

Бид Крипто Үндэстэн ХК (цаашид "компани" гэх)-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ. Бид, компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухай өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.


**КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>	
<i>Тайлагнах хугацаа</i>	2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	Крипто Үндэстэн ХК, 9007001008, 410001002, MSE:CNF
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа /Гадаад худалдаа/
<i>Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо</i>	“Хүлэгт Хүннү Аудит” ХХК, СЗХ-ны 2013 оны 9-р сарын 18-ны өдрийн 297-р тогтоол
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	113,212 ширхэг
<i>Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	Бэлтгэсэн: Б.Тэлмүүн Хянасан: Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

<i>Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>	
<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>	<u>Тайланг хавсаргав</u> (Хавсралт 3)
1. <i>Орлогын тайлан</i>	<u>Тайланг хавсаргав</u> (Хавсралт 4)
<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>	<u>Тайланг хавсаргав</u> (Хавсралт 5)
<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	<u>Тайланг хавсаргав</u> (Хавсралт 6)
1.1 <i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>	
	<u>Аудитын дүгнэлтийг хавсаргав</u> (Хавсралт 2)
1.2 <i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i>	
	<u>Аудитын тодорхойлох захидлыг хавсаргав</u> (Хавсралт 1)
2. <i>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</i>	
2.1 <i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Нийт хөрөнгийн өгөөж (ROA): -1.5% Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): -1.8%



2.2	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	
2.3	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	Олон улсын криптовалютын ханшийн өсөлт бууралт нөлөөлнө.
2.4	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл</i>	Санхүүгийн тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
2.5	<i>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл</i>	Тайлант хугацаанд зээл аваагүй болно.
3.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>	
	Компанийн нэр: Ард Бит ХХК Гэрээний нэр: Авлагын гэрээ Гэрээний хугацаа: 1 жил Гэрээний дүн: 784,863,624 төгрөг бүхий хөрөнгө Ач холбогдол: Үйл ажиллагааны эрсдлийг бууруулж, өгөөж хүртэх боломжийг бүрдүүлсэн.	
4.	<i>Цалин урамшууллын мэдээлэл</i>	
	2023 онд Крипто Үндэстэн ХК нь 2 үндсэн ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж, нийт 49.1 сая төгрөгийн цалингийн зардал гарсан байна.	
5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>	
	Крипто Үндэстэн ХК-ийн ТУЗ нь 2023 онд нийт 6 удаа ээлжит болон эчнээ хэлбэрээр хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажиллалаа. Мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болсон байна.	
6.	<i>Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</i>	
	Олон улсын криптовалютын ханшийн өсөлт бууралт нөлөөлнө.	
7.	<i>Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</i>	
	Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо: 2,502 1. Ард Даатгал ХК: 22.1% 2. Ард Бит ХХК: 17.8% 3. Эйч Ви Эл Эл ХХК: 8.5% 4. Ардын Тэтгэврийн Данс ХХК: 7.1% 5. Ард Санхүүгийн Нэгдэл ХК: 5.8%	
8.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</i>	
	Хөрөнгө татан төвлөрүүлээгүй.	
9.	<i>Ногдол ашигийн мэдээлэл</i>	
	Крипто Үндэстэн ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 3 сарын 22-ны өдрийн №24/08 тоот тогтоолоор компанийн үйл ажиллагааг цаашид хэвийн тогтвортой явуулахтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.	

10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл	
	<ul style="list-style-type: none"> <li>• “Бид илүү байж чадна” аян</li> </ul>	
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
<p>Овог, нэр: О.Мөнх-Оргил</p> <p>Албан тушаал: “Крипто Үндэстэн” ХК-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>Огноо: 2024-05-10</p> <p>(Тамга/тэмдэг)</p> 	<p>Овог, нэр: Б.Тэлмүүн</p> <p>Албан тушаал: “Крипто Үндэстэн” ХК-ийн ерөнхий нягтлан бодогч</p> <p>Гарын үсэг: ...<i>Б.Тэлмүүн</i>.....</p> <p>Огноо: 2024-05-10</p>	



Г САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ Г  
ХОРОО-д

**"ХҮЛЭГТ ХҮННҮ АУДИТ" ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
6-р хороо, Бага тойруу /14201/, Самбуугийн гудамж  
6-р барилга 4-р давхар, 402 тоот  
Web: www.hulegthumnu.mn, E-mail: info@hulegthumnu.mn  
Утас: 70140505, 99100064

2024.04.12 № 24/166  
№

Г Тодорхойлох захидал Г

Эрхэм хүндэт танаа,

"Хүлэгтхүннү аудит" ХХК нь "Крипто үндэстэн" ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тусдаа санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар тусдаа орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.

Бидний 2023 оны 03 сарын 28-ний өдөр хүргүүлсэн хараат бус аудитын тайланд тусгасанчлан компанийн тусдаа санхүүгийн тайлангууд нь компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тусдаа орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний бүх материаллаг талаараа СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн гэж дүгнэсэн.

Бид аудит хийхдээ Аудитын Олон Улсын Стандарт (АОУС) болон ёс зүйн шаардлагуудыг мөрдөн ажилласан ба манай аудитын компани болон аудитыг гүйцэтгэсэн аудитын багийн гишүүд нь үйлчлүүлэгчтэй сонирхлын зөрчилгүй, үйлчлүүлэгчтээ хараат бус байдлаар ажилласан болно.

Санхүүгийн мэдээлэл болон энэхүү албан тодорхойлолт нь компанийн тусдаа санхүүгийн тайлангуудад гаргасан аудитын дүгнэлтийг орлохгүй бөгөөд СТОУС болон Монгол Улсын хууль, дүрэм журмаар шаардсан нэмэлт бүх тодруулга, мэдээллийг агуулаагүй болно.

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ И.ГҮРРАГЧАА





## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### КРИПТО ҮНДЭСТЭН ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

#### Дүгнэлт

Бид Крипто үндэстэн ХК (цаашид "компани" гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "МНБЕЗ-н дүрэм" гэх)-ийн дагуу компаниас хараат бус ба МНБЕЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

#### Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

#### Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй

★ "Хүлээгтхүннү аудит" ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,  
Бага тойруу /14201/, Самбуугийн гудамж 6-р барилга 4 давхар, 402 тоот  
Утас/Факс: +(976)-7014 0505

нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудитын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудитын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсоход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Гарын үсэг зурвал:



И.үррэгчаа  
Гүйцэтгэх захирал  
Хүлэгтхүннү Аудит ХХК

2024 оны 03 дүгээр сарын 28-ны өдөр  
Монгол Улс, Улаанбаатар хот

КРИПТО ҮНДЭСТЭН ХК  
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр	Тодруулгын дугаар	2023 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>Хөрөнгө</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5	995,189	469,795
Дансны авлага	6	760,617,975	759,188,169
Бусад авлага	7	38,148,870	10,498,686
Бусад санхүүгийн хөрөнгө	8	216,473,390	201,020,000
Урьдчилж төлсөн зардал	9	278,205,604	5,386,679
Бусад эргэлтийн хөрөнгө	10	4,485,059,267	3,971,933,572
		<b>5,779,500,295</b>	<b>4,948,496,901</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	11	1,495,848	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	12	-	29,487,968
		<b>1,495,848</b>	<b>29,487,968</b>
<b>Нийт хөрөнгө</b>		<b>5,780,996,143</b>	<b>4,977,984,869</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Дансны болон бусад өглөг	13	609,035,804	381,813,695
Татварын өглөг	14	3,447,600	671,322
		<b>612,483,404</b>	<b>382,485,017</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Хойшлогдсон татварын өр төлбөр	15	157,678,262	(0)
		<b>157,678,262</b>	<b>(0)</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		<b>770,161,666</b>	<b>382,485,017</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	16	11,321,200	11,321,200
Нэмж төлөгдсөн капитал		8,421,200	8,421,200
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	17	1,419,104,354.7	0
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	18	3,464,259,336	4,380,000,000
Хуримтлагдсан ашиг алдагдал		107,728,387	195,757,452
<b>Эздийн өмчийн дүн</b>		<b>5,010,834,477</b>	<b>4,595,499,852</b>
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>		<b>5,780,996,143</b>	<b>4,977,984,869</b>

11-24 дүгээр хуудсанд хавсаргасан нэмэлт тодруулагууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



КРИПТО ҮНДЭСТЭН ХК  
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Төгрөгөөр	Тодруулгын дугаар	2023 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)		-	-
Борлуулсан барааны өртөг		-	-
Нийт ашиг (алдагдал)		-	-
Түрээсийн орлого		-	-
Хүүний орлого	19	28,004,508	10,238,509
Бусад орлого	20	19,782,985	110,734,516
Ерөнхий ба удирдлагын зардал	22	143,486,120	236,087,504
Бусад олз (гарз)	21	7,463,583	62,211,663
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>(88,235,044)</b>	<b>(52,902,816)</b>
Орлогын татварын зардал		-	-
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>(88,235,044)</b>	<b>(52,902,816)</b>
<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал</b>		-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>		<b>(88,235,044)</b>	<b>(52,902,816)</b>
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Орлогын нийт дүн		(88,235,044)	(52,902,816)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		(779.38)	(467.29)

11-24 дүгээр хуудсанд хавсаргасан нэмэлт тодруулагууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

КРИПТО ҮНДЭСТЭН ХК  
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

**Төгрөгөөр**

	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31</b>	11,321,200	8,421,200	0	4,380,000,000	248,660,268	4,648,402,669
Залруулсан үлдэгдэл	11,321,200	8,421,200	0	4,380,000,000	248,660,268	4,648,402,669
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	-	(52,902,816)	(52,902,816)
<b>2022 оны 12-р сарын 31</b>	11,321,200	8,421,200	0	4,380,000,000	195,757,452	4,595,499,852
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	205,979	205,979
Залруулсан үлдэгдэл	11,321,200	8,421,200	0	4,380,000,000	195,963,431	4,595,705,831
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	-	(88,235,044)	(88,235,044)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	1,419,104,355	(915,740,665)	-	503,363,690
<b>2023 оны 12-р сарын 31</b>	11,321,200	8,421,200	1,419,104,355	3,464,259,336	107,728,387	5,010,834,477

11-24 дүгээр хуудсанд хаасараасан нэмэлт тодруулууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй

2/10



КРИПТО ҮНДЭСТЭН ХК  
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төгрөгөөр	2023 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн (+)	187,048,363	65,316,952
Бусад мөнгөн орлого	187,048,363	65,316,952
Мөнгөн зарлагын дүн (-)	169,415,932	65,861,496
Ажиллагчдад олгосон мөнгө	43,198,500	8,898,043
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	6,260,000	3,080,154
Ашиглалтын зардал төлсөн	26,829,891	21,940,381
Татварын байгууллагад төлсөн	2,667,072	3,052,214
Бусад мөнгөн зарлага	90,460,469	28,890,704
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>17,632,431</b>	<b>(544,544)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн зарлагын дүн (-)	17,103,772	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,495,848	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	15,607,924	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(17,103,772)</b>	<b>-</b>
Валютын ханшны зөрүү	(3,265)	-
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>525,394</b>	<b>(544,544)</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>469,795</b>	<b>1,014,339</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>995,189</b>	<b>469,795</b>

11-24 дүгээр хуудсанд хавсаргаасан нэмэлт тодруулауд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.